



МОНГОЛЫН БАНК БУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ХОЛБОО

FIRST
TERELJ FEST® **MEETING**
FESTIVAL

SEPTEMBER 21 2019 SATURDAY

ХАМТ ОЛОНТОЙГОО ГАЙХАЛТАЙ ДУРСАМЖИЙГ БҮТЭЭ...

**МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
“ТЭРЭЛЖ ФЕСТИВАЛЬ-2019” ТАНИЛЦАХ ӨДӨРЛӨГ**

НЭГ. ХУРААНГУЙ

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос энэ жил анх удаагаа цэвэр агаарт сургалт&спорт&урлаг- ийн нэгдсэн томоохон цугларалт, танилцах өдөрлөгийг зохион байгуулах гэж байна. Энэхүү өдөрлөгөөр гишүүн банк бус санхүүгийн байгууллагуудын ажилтнуудын авъяас, мэдлэг, ур чадваруудыг нийтэд алдаршуулж хамт олонтойгоо нэг өдрийг эрүүл, зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

ХОЁР. ЗОРИЛГО

Хамт олонтойгоо гайхалтай дурсамжийг бүтээх

ГУРАВ. ЗОРИЛТ&ЭВЭНТ

- Хөлбөмбөгийн тэмцээн /Холимог баг /
- Хамт олны гадаад орчны сургалт /Холимог/
- NBF1 awards /Банк бусаараа /
- Галын наадам&диско /Чөлөөтэй/

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ:

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны гишүүн ББСБ-ийн хамт олон

ТАВ. ХУГАЦАА:

2019.09.21 Тэрэлж Бумбан Тур жуулчны бааз

ЗУРГАА. ТӨЛБӨР:

Нэг хүний 65000 төгрөг байна.

ДОЛОО.ТӨЛБӨРТ БАГТСАН ЗҮЙЛС:

- Ирж буцах автобус
- Өдөр, оройн хоол
- Шар айраг -2 ш
- Байрлах гэр
- Бүх тэмцээний шагналын сан
- Шоу тоглолт диско

НАЙМ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Хөлбөмбөг/холимог баг

- I- Алтан медаль, мөнгөн шагнал
- II- Мөнгөн медаль, мөнгөн шагнал
- III-Хүрэл медаль, мөнгөн шагнал

NBF1 awards Урлагийн наадам

- I-Шилдгийн шилдэг үзүүлбэр номинаци
- II-Олны таашаал номинаци
- III- Шилдэг хамтлаг номинаци
- IV- Шилдэг соло номинаци
- V- Шилдэг CEO номинаци

“ТЭРЭЛЖ ФЕСТИВАЛЬ-2019” ТАНИЛЦАХ ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

2019.09.21 Бямба гариг

07:00-08:00 Сүхбаатарын талбайд цугларах

08:30 Автобус хөдлөх

10:30 “Тэрэлж бумбан тур” жуулчны баазад хүрэх

10:30 “Гэгээн өглөө” угтах үйл ажиллагаа

10:40-11:00 Хувиарлагдсан гэрүүдэд байрлах

11:00-11:30 “Best breakfast time” шалгаруулах

11:30-12:00 Чөлөөт цаг

12:00-“Танилцъя талын цэцэг” баг зохион байгуулалт, гадаад орчны сургалт

12:40-14:00 “Happy time” тэмцээн /шинээр хувиарлагдсан багуудын дунд/

14:00 “Тэрэлж фестиваль 2019” өдөрлөгийн нээлт

14:00-15:00 Өдрийн хоол “Хорхог+Айраг”

15:00-18:00 Холимог хөлбөмбөгийн тэмцээн

16:00-16:40 “Are you ready!!!” Өртөөчилсэн суралцах цаг

- Бүжиг
- Анхаарал
- Оригами
- Дуут тоглоом

18:00 Оройн зоог+2 beer

19:00 “**NBFI awards-нээлттэй урлагийн наадам**”

20:10 Шагнал гардуулах ёслолын арга хэмжээ

20:20 Амьд хөгжмийн хамтлагийн тоглолт

20:50 DJ set диско бүжиг

22:00 Арга хэмжээ өндөрлөх

23:00 Автобус Улаанбаатар хотруу хөдлөх

00:00-01:00 Цагийн үед Улаанбаатар хотод очно МУБИС-н гадаа ирнэ.

Жич: Арга хэмжээнд оролцогчид хувийн бэлтгэлээ сайн хангаж дулаан , биед эвтэйхэн хувцастай ирэхийг зөвлөж байна. Одоогийн байдлаар цаг уурын хүрээлэнгээс бидэнд мэдэгдэснээр тухайн 21- ний өдөр +15 градус нартай байна гэсэн шүү!

Анхаарах зүйл:

- Өглөө цуглахаас эхлээд үйл ажиллагааны цагийг нарийн баримтлана.
- Жуулчны баазад үргэлжлүүлэн үйлчлүүлэх тохиолдолд тухайн баазтай ярилцаж тохирно.
- Ирж буцахдаа хамт олноо бүртгэж, нэгнээ хаяж гээхгүй байх
- Өөрийн эд зүйлсээ хаяж үрэгдүүлэхгүй байх
- Бусдын эд зүйлийг эвдэлж гэмтээхгүй байх.

“ХОЛИМОГ ХӨЛБӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ”

НЭГ. ЗОРИЛГО:

Спортоор дамжуулан залуучуудыг хооронд нь нөхөрлүүлж танилцуулах, цэвэр агаарт спорт тоглоом тоглох.

ХОЁР. БАГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Баг:

Нийт 8 тамирчдаас бүрдэнэ.

Талбай дээр тоглохдоо:

Эрэгтэй 5

Эмэгтэй 2

Багийн гишүүд:

Нэг банк бус санхүүгийн байгууллагаас 2-с илүү гишүүн нийлэхгүй байна.

Багийн нэр:				
№	Тамирчдын нэрс	Хүйс	Нас	Банк бусын нэр	Холбоо барих утас
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

- Тэмцээн холимог шүүлтийн системээр болно
- Багууд хэсэгт хуваагдаж тойргоор, хэсгээс гараад олимпийн системээр тоглоно.
- Тоглолтын 1 үе 7 минут, 2 үед нийт 14-15 минут байна

ДӨРӨВ. ХАМРАХ ХҮРЭЭ:

- Нийт 8 баг оролцоно /нэмж, хасахгүй 8 багийг бүртгэнэ./
- Зөвхөн гишүүн ББСБ-н фестивалийн хураамж төлсөн, насанд хүрсэн хүн байна.

“А” хэсэг

№		1	2	3	4
1	Баг 1	■			
2	Баг 2		■		
3	Баг 3			■	
4	Баг 4				■

“В” хэсэг

№		1	2	3	4
1	Баг 1	■			
2	Баг 2		■		
3	Баг 3			■	
4	Баг 4				■

ТАВ.ШАГНАЛЫН САН

- 1- р байр Алтан медаль, мөнгөн шагнал
- 2- р байр Мөнгөн медаль, мөнгөн шагнал
- 3- р байр Хүрэл медаль, мөнгөн шагнал

“NBFI AWARDS-УРЛАГИЙН НААДМЫН УДИРДАМЖ”

НЭГ. ЗОРИЛГО:

Банк бус санхүүгийн байгууллагад ажилладаг урлагийн шинэ авъяастныг тодруулах, алдаршуулах.

ХОЁР. ОРОЛЦОХ ТӨРӨЛ:

Урлагийн ямар ч төрөл, жанрын үзүүлбэрийг үзүүлж болох бөгөөд ганцаараа, хамтлаг, хамт олноороо оролцох боломжтой.

ГУРАВ. ҮЗҮҮЛБЭРИЙН ТОО:

Нэг Банк бус санхүүгийн байгууллагаас 2-с дээш үзүүлбэр оролцуулахгүй.

ДӨРӨВ. ҮЗҮҮЛБЭРИЙН ХУГАЦАА:

Үзүүлбэр 4 минутаас урт байж болохгүй /цаг баримтлал шүүлтэнд нөлөөлнө./

ТАВ: БУСАД ЗҮЙЛ:

- Мэргэжлийн хөгжим, задгай тайз, микрофоноор хангана
- Ая шуумаа урьдчилж хөгжмийн хүнд файлаар өгнө /тэр өдөр/

“BEST BREAKFEAST TIME” ТУХАЙ

ХУРААНГУЙ.

Энэ нь байгууллага хамт олноороо цэвэр агаарт цайлах үйл ажиллагаа юм. Банк бус санхүүгийн байгууллагуудын ажилтнууд өглөөний цайг өөрсдөө бэлтгэж ирэх бөгөөд хамт олноороо ярилцаж зохион байгуулалттай оролцож болно.

“ТАНИЛЦЪЯ ТАЛЫН ЦЭЦЭГ” БАГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ГАДААД ОРЧНЫ СУРГАЛТ

ХУРААНГУЙ.

Энэхүү фестивалд хүрэлцэн ирсэн бүх хүмүүсийн дунд зохион байгуулагдах гадаад орчны сургалт юм. Ажилтнаас шаардагдах ямар нэг зүйл байхгүй, мэргэжлийн сургагч багш нар удирдан зохион байгуулна. Сургалт нь хөгжилтэй нөхөрсөг байдлаар явагдана. Ирсэн бүх хүмүүс хамрагдах ёстой.

“HAPPY TIME” БУУХИА ТЭМЦЭЭН

ХУРААНГУЙ.

Янз бүрийн банк бус санхүүгийн байгууллагын ажилтнуудаас бүрдсэн шинэ багуудын дунд зохиогдоно. 3-4 төрлийн хөгжилтэй этап, буухиа, хамт олны болон ганцаарчилсан тэмцээнүүд зохиогдож түрүүлсэн баг шагналын эзэд болно.

“ARE YOU READY!!!” ӨРТӨӨЧИЛСӨН СУРАЛЦАХ ЦАГ

ХУРААНГУЙ.

Цагийг зугаатай, хөгжилтэй бие биетэйгээ илүү дотно танилцах боломжийг энэхүү суралцах цаг олгоно. Тусгайлан бэлтгэсэн 4 төрлийн өртөөгөөр өртөөчилж суралцах юм. Үүнд өөрийнхөө анхаарлыг шалгаж, шинэ бүжиг суралцаж, гарын эв дүйгээ шалгаж шинэ дуут тоглоом сурах гэх мэт сонирхолтой өртөөнүүдэд 10-15 минут саатан оролцоно. Өртөөчилсэн суралцах цагийг мэргэжлийн багш сургагч нар удирдан зохион байгуулна.